



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/89/СТА-ТШЗ

| | |
|---|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он</p> | <p>Дорнод аймаг дахь Төрийн аудит газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Батжаргал Утас: 70584207 Цахим хаяг: Batjargalb@audit.gov.mn</p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДОА | Аудитын Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НББ | Нягтлан бодох бүртэл |



Агуулга

| | |
|--|----|
| Аудитын гэрчилгээ | 3 |
| Аудитын тайлан | 4 |
| 2.1. Оршил..... | 4 |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 4 |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 4 |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин..... | 5 |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ..... | 5 |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 5 |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 6 |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 6 |
| 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга | 6 |
| 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... | 7 |
| 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал..... | 8 |
| 2.12. Шилэн дансны мэдээлэл..... | 8 |
| 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт | 8 |
| 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл | 8 |
| Менежментийн захидал | 9 |
| Аудит хийгдсэн санхүүгийн тайлан | 10 |
| 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан | 10 |
| 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 11 |
| 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 12 |
| 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 14 |
| 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 15 |





2.1. Оршил

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Н.Энхболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-аас 2020 оны 02 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Б.Батжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас



санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн эрхэм зорилго нь “Монгол улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд Стандарт, чанар хэмжил зүйн бодлого үйл ажиллагаагаар дэмжих, “Стандарт, тохирлын үнэлгээний тухай” хууль, “Хэмжлийн нэгдмэл байдлын тухай” хууль, хэрэглэгчдийн эрхийг хамгаалах төр захиргааны тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулж үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх”-д оршино.

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирлын үнэлгээ баталгаажуулалт
- Хэмжих хэрэгслийн баталгаажуулалт
- Стандарт, мэдээллийн үйлчилгээ, сургалт, мэдээлэл, арга зүйн зөвлөгөө өгөх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Стандарт хэмжил зүйн хэлтсийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Стандарт хэмжил зүйн хэлтэс нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Аcoluos программ хангамж ашигладаг байна.

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Стандарт, хэмжил зүйн хэлтсийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.



2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 284,150.3 мянган төгрөгөөс тооцон 5,683.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 6,795.9 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой байна.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 253.7 мянган төгрөгөөр буюу 0.23 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | Хувь |
|---|------------------|------------------|----------|--------|
| Б | 1 | 2 | 3=2-1 | |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 | |
| Авлага | 0 | 0 | 0 | |
| Урьдчилгаа | 0 | 0 | 0 | |
| Бараа материал | 7,019.1 | 5,412.5 | -1606.6 | -22.89 |
| Үндсэн хөрөнгө | 264,397.4 | 286,485.6 | 22088.2 | 8.35 |
| Хуримтлагдсан элэгдэл | -160,390.1 | -180,617.9 | -20227.8 | |
| Нийт хөрөнгө | 111,026.4 | 111,280.2 | 253.8 | 0.23 |
| Өр төлбөр | 34.9 | - | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 110,991.5 | 111,280.2 | 288.7 | 0.26 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 111,026.4 | 111,280.2 | 253.8 | 0.23 |

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 1,606.0 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 22,088.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар суудлын автомашин худалдан авсантай холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 60,000.0 мянган төгрөг батлагдсан байна. Гүйцэтгэлээр тайлант онд улсын төсөвт 120,708.8 мянган төгрөг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 201.1%-аар давуулан биелүүлсэн байна. Орлого нэмэгдсэн шалтгаан нь үйл ажиллагааны цар хүрээ, стандарт болон баталгаажуулалтын тоо хэмжээ нэмэгдсэн. Мөн Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 22 дугаар тушаалын 1-р хавсралтад заасан схемийн дагуу бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын ажлын төлбөрийн хэмжээнд өөрчлөлт орж нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 187,824.4 мянган төгрөг урсгал зардалд зарцуулагдахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 30,000.0 мянган төгрөг, өөрийн орлого 1,553.0 мянган төгрөг нийт 31,553.0 мянган төгрөгийн нэмэлт төсвийг бүрдүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн 31,553.0 мянган төгрөгийг хөрөнгө худалдан авахад зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 11 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 33,409.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 205.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 31,513.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1,690.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 1 зөвлөмж өгөв.

Аудитаар 33,409.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 31,513.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 205.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

1. Ажилтнуудын ээлжийн амралтын мөнгө бодохдоо хоол унаанд олгосон мөнгийг оруулж тооцон нийт 205,2 мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь *Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ын 4-т "Ажилтанд олгож байгаа бүр төрлийн /жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвараа алдсаны, ажилгүйдлийн, тэтгэвэрт гарах үеийн ажилтанд олгох гэх мэт/ тэтгэмжүүд, нөхөх олговор, хөнгөлөлтийн орлого, /унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлт/-ыг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй."* гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Бараа материалын худалдан авалтын 82 хувь буюу 31,513.3 мянган төгрөгийн анхан шатны баримтад е-баримтыг хавсаргаагүй нь *Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 3.1.3 дахь заалтад "анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13.4 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад*



бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, 13.5 дахь хэсэгт “... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч E баримтыг хавсаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 1,690.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 666.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,553.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2019.04.15-ны №67 дугаар бүхий албан бичгээр хариу ирүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дугаар зүйл, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *МУЕА-аас өгсөн чиглэлийн дагуу суудлын автомашины ашиглалтын талаар*

1.1. *Илрүүлэлт:* Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга нь Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолд заасны дагуу албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтад хамаарахгүй байхад тодорхой ажлын гүйцэтгэлгүйгээр 1,690.7 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.

1.2. *Эрсдэл:* Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

1.3. *Өгсөн зөвлөмж:* Засгийн газраас гаргасан тушаал шийдвэрийг мөрдөж ажиллах

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Өгсөн зөвлөмжийг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>7,019,078.00</u> | <u>5,412,478.00</u> |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 7,019,078.00 | 5,412,478.00 |
| 354 | Хангамжийн материал | 5,466,078.00 | 5,412,478.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,475,920.00 | 983,920.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,990,158.00 | 4,428,558.00 |
| 35600 | Мал амьтад | 1,553,000.00 | 00.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>104,007,381.27</u> | <u>105,867,701.18</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 104,007,381.27 | 105,867,701.18 |
| 392 | Биет хөрөнгө | 74,382,381.27 | 76,242,701.18 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 25,982,107.00 | 25,982,107.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -3,711,729.60 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 23,872,300.00 | 53,872,300.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -15,205,633.57 | -20,018,133.61 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 171,946,600.00 | 163,704,900.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -138,197,008.66 | -148,821,383.35 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 10,909,356.00 | 11,239,356.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -4,925,339.50 | -6,004,715.26 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,512,000.00 | 1,512,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,512,000.00 | -1,512,000.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 29,625,000.00 | 29,625,000.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -550,000.00 | -550,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 29,625,000.00 | 29,625,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>111,026,459.27</u> | <u>111,280,179.18</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>34,925.14</u> | <u>00.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 34,925.14 | 00.00 |
| 413 | Өглөг | 34,925.14 | 00.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 34,925.14 | 00.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>110,991,534.13</u> | <u>111,280,179.18</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 110,991,534.13 | 111,280,179.18 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 85,610,124.00 | 85,610,124.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 85,610,124.00 | 85,610,124.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -1,281,696.87 | -993,051.82 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -1,281,696.87 | -1,281,696.87 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 288,645.05 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 26,663,107.00 | 26,663,107.00 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>111,026,459.27</u> | <u>111,280,179.18</u> |

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 282,060,699.00 | 338,533,240.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 76,621,299.00 | 120,708,840.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 76,621,299.00 | 120,708,840.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 76,621,299.00 | 120,708,840.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 76,621,299.00 | 120,708,840.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 205,439,400.00 | 217,824,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 169,439,400.00 | 187,824,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 169,439,400.00 | 187,824,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 00.00 | 30,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 30,000,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 284,150,340.29 | 339,797,594.95 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 284,150,340.29 | 339,797,594.95 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 188,950,435.52 | 198,719,642.96 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 120,045,912.61 | 132,820,346.27 |
| 210101 | Үндсэн цалин | 80,954,612.61 | 114,058,006.27 |
| 210102 | Нэмэгдэл | 13,160,000.00 | 14,141,800.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,987,500.00 | 4,620,540.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 14,537,241.00 | 16,617,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 9,528,809.27 | 11,299,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 921,917.83 | 1,329,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,209,793.90 | 1,063,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 241,684.00 | 265,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,635,036.00 | 2,658,800.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 4,168,000.00 | 3,031,116.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 715,200.00 | 466,563.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,892,837.00 | 1,757,289.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 559,963.00 | 807,264.60 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,951,559.49 | 6,582,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,710,060.00 | 1,305,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,131,500.00 | 3,231,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,016,239.49 | 809,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 243,400.00 | 286,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 527,300.00 | 950,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,798,400.00 | 540,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,998,400.00 | 540,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,409,400.00 | 5,677,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,409,400.00 | 5,677,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,326,870.00 | 1,283,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 240,000.00 |



| | | | |
|-------------|---|-----------------------------|-----------------------------|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 54,450.00 | 54,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 38,500.00 | 38,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 132,000.00 | 732,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 93,500.00 | 93,500.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 77,200.00 | 91,800.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,713,052.42 | 32,167,680.09 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,318,750.00 | 2,037,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,691,120.00 | 438,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 24,703,182.42 | 29,692,680.09 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 95,199,904.77 | 141,077,951.99 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 00.00 | 20,278,600.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 19,478,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 800,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 95,199,904.77 | 120,799,351.99 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 95,199,904.77 | 120,799,351.99 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>-2,089,641.29</u> | <u>-1,264,354.95</u> |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 00.00 | 1,553,000.00 |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | 00.00 | 1,553,000.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -327,158.11 | 1,553,000.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>-2,416,799.40</u> | <u>288,645.05</u> |

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|------------------------------|------------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>282,060,699.00</u> | <u>340,086,240.00</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | <u>76,621,299.00</u> | <u>120,708,840.00</u> |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 76,621,299.00 | 120,708,840.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 76,621,299.00 | 120,708,840.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 76,621,299.00 | 120,708,840.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | <u>205,439,400.00</u> | <u>219,377,400.00</u> |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 169,439,400.00 | 187,824,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 169,439,400.00 | 187,824,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 00.00 | 31,553,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 30,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 1,553,000.00 |



| | | | |
|--------|---|-----------------------|-----------------------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 282,060,699.00 | 308,533,240.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 282,060,699.00 | 308,533,240.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 186,860,794.23 | 167,455,288.01 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 120,011,987.20 | 132,855,271.41 |
| 210101 | Үндсэн цалин | 80,920,687.20 | 114,092,931.41 |
| 210102 | Нэмэгдэл | 13,160,000.00 | 14,141,800.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,987,500.00 | 4,620,540.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 14,506,905.54 | 16,617,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 9,594,305.54 | 11,299,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 982,500.00 | 1,329,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,228,200.00 | 1,063,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 245,700.00 | 265,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,456,200.00 | 2,658,800.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 4,168,000.00 | 3,031,116.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 715,200.00 | 466,563.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,892,837.00 | 1,757,289.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 559,963.00 | 807,264.60 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 11,181,039.49 | 5,769,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,663,500.00 | 463,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,131,500.00 | 3,231,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,121,239.49 | 809,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 265,000.00 | 265,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,999,800.00 | 1,000,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 22,799,650.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,999,650.00 | 1,000,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,409,400.00 | 5,677,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,409,400.00 | 5,677,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,499,712.00 | 1,359,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 240,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 54,450.00 | 54,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 38,500.00 | 38,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 132,000.00 | 732,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 93,500.00 | 93,500.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 148,500.00 | 167,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,284,100.00 | 1,146,100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,800,000.00 | 662,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,484,100.00 | 484,100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 95,199,904.77 | 141,077,951.99 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 00.00 | 20,278,600.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 19,478,600.00 |



| | | | |
|--------|--|---------------|-----------------------|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 800,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 95,199,904.77 | 120,799,351.99 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 95,199,904.77 | 120,799,351.99 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 00.00 | 31,553,000.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 00.00 | 31,553,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 00.00 | 31,553,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 00.00 | 31,553,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 31,553,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | 00.00 | -31,553,000.00 |

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|----------------------|---|
| C01 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 85,610,124.00 | 26,663,107.00 | -1,281,696.87 | 110,991,534.13 |
| D01 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 85,610,124.00 | 26,663,107.00 | -1,281,696.87 | 110,991,534.13 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 85,610,124.00 | 26,663,107.00 | -1,281,696.87 | 110,991,534.13 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 288,645.05 | 288,645.05 |
| D09 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 85,610,124.00 | 26,663,107.00 | -993,051.82 | 111,280,179.18 |

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|---|-----------------------|----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 187,824,400.00 | 187,733,888.01 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 187,824,400.00 | 187,733,888.01 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 167,545,800.00 | 167,455,288.01 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 132,938,900.00 | 132,855,271.41 |
| 210101 | Үндсэн цалин | 114,144,100.00 | 114,092,931.41 |
| 210102 | Нэмэгдэл | 14,141,800.00 | 14,141,800.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,653,000.00 | 4,620,540.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 16,617,400.00 | 16,617,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,299,800.00 | 11,299,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,329,400.00 | 1,329,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,063,500.00 | 1,063,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 265,900.00 | 265,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,658,800.00 | 2,658,800.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 3,032,000.00 | 3,031,116.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 467,200.00 | 466,563.00 |
| 210302 | Түлш, халаалт | 1,757,300.00 | 1,757,289.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 807,500.00 | 807,264.60 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,769,000.00 | 5,769,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 463,500.00 | 463,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,231,500.00 | 3,231,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 809,000.00 | 809,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 265,000.00 | 265,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,683,400.00 | 5,677,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,683,400.00 | 5,677,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,359,000.00 | 1,359,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | 240,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 54,500.00 | 54,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 38,500.00 | 38,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 732,000.00 | 732,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 93,500.00 | 93,500.00 |



| | | | |
|---------------|---|-----------------------|-----------------------|
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 167,500.00 | 167,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1146100.00 | 1146100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 662,000.00 | 662,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 484,100.00 | 484,100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 20278600.00 | 20278600.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 20,278,600.00 | 20,278,600.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 19,478,600.00 | 19,478,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 | 800,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 247,824,400.00 | 308,483,740.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 187,824,400.00 | 187,824,400.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 187,824,400.00 | 187,824,400.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 60,000,000.00 | 120,659,340.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 60,000,000.00 | 120,659,340.00 |